



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 3 сарын 17 өдөр

Дугаар: 4

Улаанбаатар хот

Дотоод аудитын 2017 оны төлөвлөгөө, төсөв батлах тухай

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1 дэхь хэсэг, Сангийн Сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 4.1.1 дэх заалт, дотоод аудитын хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Дотоод аудитын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, хорооны үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Дотоод аудитын хорооны үйл ажиллагаанд зориулагдах батлагдсан төсвийг холбогдох зардлаас гарган ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /З.Мэндсайхан/, Санхүүгийн хэлтсийн дарга /Б.Баясгалан/ нарт тус тус үүрэг болгосугай.


Гурав. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, Дотоод аудитын хороонд танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Сандуйжав/-д даалгасугай.

САЙД, ДОТООД АУДИТЫН  
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНХҮҮ

Дотоод аудитын хорооны  
2017 оны 3 дүгээр сарын 7-ны  
өдрийн 4 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



## I. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү Аудитын Жилийн Төлөвлөгөөнд аудитын ажил бүрт тавигдах зорилго зарцуулах хугацаа, шаардлагатай нөөцүүдийг харуулсан. 2017 онд хийгдэх аудитын ажлуудыг Дотоод Аудитын нэгжид бодитойгоор ашиглах хүний нөөцийн чадавхид үндэслэн тодорхойлсон.

Аудитын Жилийн Төлөвлөгөөг тухайн жилийн туршид байнга хянаж, байгууллага эсвэл Дотоод Аудитын нэгжийн ажиллах бүрэлдэхүүнд гарсан томоохон өөрчлөлтүүдийг тусгахын тулд байнга шинэчлэнэ. Мөн байгууллагын удирдлагын шийдвэрээр тусгайлан аудитын ажил хийж гүйцэтгэх бол тэдгээрийг жилийн төлөвлөгөөнд нэмж тусгаж болно. Төлөвлөгөөнд хийгдсэн бүх өөрчлөлтүүдийг Дотоод Аудитын Хороогоор батлуулна.

## II. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ЗОРИЛГЫГ ХАНГАХАД ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэхийн тулд 2017 онд Дотоод Аудитын нэгж дараах аудитын ажил болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн:

№	Стратеги зорилго	Стратеги зорилгыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа	Хийгдэх аудитын ажил
1	Салбарын бодлогын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод хяналт, шалгалт, аудит хийх, статистик мэдээллээр хангах	Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, холбогдох хуулийн дагуу дотоод хяналт, шалгалт, дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах	<ol style="list-style-type: none"><li>1. Төрийн өмчит хувьцаат компани, төрийн өмчийн үйлдвэрийн газруудын 2016 оны үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх. Төрийн өмчит 5 компанийг хамруулна.</li><li>2. Сайдын багцын 2016 оны төсвийн:<ul style="list-style-type: none"><li>- урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод аудит хийх</li><li>- худалдан авалтын үйл ажиллагаанд дотоод аудит хийх</li><li>- Шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэгт дотоод аудит хийх.</li></ul></li><li>3. Эрчим хүчний салбарын төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх.</li></ol>



### III. ХИЙГДЭХ АУДИТЫН АЖЛУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

#### 3.1. Өмнөх жилд төлөвлөсөн боловч хийгдээгүй ажлууд

2016 оны Аудитын Жилийн Төлөвлөгөөнд багтсан 8 багц аудитын ажлаас тухайн төлөвлөсөн жилдээ 7 аудит хийгдсэн. 2016 оны аудитын ажлын төлөвлөгөөг 4 аудиторoor тооцоолон батлуулсан боловч 2016 оны 9 дүгээр сард яамны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж 2 аудитор ажиллах болсонтой холбоотой 1 аудит хийгдээгүй. Үүнд:

- "Эрчим хүчний салбарын төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудит"-ыг 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан.

#### 3.2. Одоогийн жилд хийхээр төлөвлөсөн аудитын ажлууд

2017 онд дараах аудитын ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Аудитын ажил	Хамаарах нэгж	Аудитын ажлын зорилго	Аудитын ажлын цар хэмжээ	Аудит хийгдэ
АА 1701	"ДЦС-4" ТӨХК	ТЕЗ-ын дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	"ДЦС-4" ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг Сангийн сайдын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 116 дугаар тушаалаар баталсан зааврын хүрээнд гүйцэтгэнэ.	2-3 сар
АА 1702	"УБЦТС" ТӨХК		"УБЦТС" ТӨХК-ийн 2016 оны үйл ажиллагаанд Эрчим хүчний сайдын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж гүйцэтгэнэ.	3-4 сар
АА 1703	"УБДус" ТӨХК		"УБДус" ТӨХК-ийн 2016 оны үйл ажиллагаанд Эрчим хүчний сайдын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж гүйцэтгэнэ.	4-5 сар

AA 1704	"ДБЭХС" ТӨХК	ТЕЗ-ын дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад	"ДБЭХС" ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг Сангийн сайдын 2010 оны 116 зарлага, дугаар тушаалаар баталсан зааврын хүрээнд гүйцэтгэнэ.	5-6 сар
AA 1705	"Багануурын ДС" ТӨХК	санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	"Багануурын ДС" ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд санхүүгийн дотоод аудитыг Сангийн сайдын 2010 оны 116 дугаар тушаалаар баталсан зааврын хүрээнд гүйцэтгэнэ.	9 сар
AA 1706	Эрчим хүчний салбарын төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх.  / 2017 он/	ТЕЗ-ын дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Сайдын багцын 2017 оны гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудитыг Сангийн сайдын 2010 оны 116 дугаар тушаалаар баталсан "Дотоод аудит явуулах заавар"-ын дагуу гүйцэтгэнэ.	10-11 сар
AA 1707	Сайдын багцын 2017 оны төсвийн:  - урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл  - худалдан авалтын үйл ажиллагаа  - шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх	ТЕЗ-ын дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Сайдын багцын 2017 оны төсвийн урсгал зарлагын төлөвлөлт, худалдан авалт, санхүүгийн бусад үйл ажиллагаа, дотоод хяналтын хэрэгжилтэд дотоод аудитыг Сангийн сайдын 2010 оны 116 дугаар тушаалаар баталсан "Дотоод аудит явуулах заавар"-ын дагуу гүйцэтгэнэ.	11-12 сар